

ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭ

1. Гэрээ байгуулагч Талууд:

1.1. Нэг талаас: Төсвийн ерөнхийлөн захирагч:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын Захирагч

(албан тушаал, нэр)

САЙНБУЯН

АМАРСАЙХАН

(эцэг/эх/-ийн нэр, нэр)

1.2. Нөгөө талаас: Төсвийн шууд захирагч

“Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл,

Технологийн Парк” ОНӨТҮГ-ын ДАРГА

(албан тушаал)

СОСОР

БАТЖАРГАЛ

(эцэг /эх/-ийн нэр, нэр)

бид дор дурдсан асуудлаар харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

2. Гэрээний агуулга, зорилго

2.1. Энэхүү гэрээний зорилго нь үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

2.2. "Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас хэрэгжүүлэх хөтөлбөр, нийт болон тусгай арга хэмжээнүүд, манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-үүд болон бусад эрх үүргийг тусгав.

НЭГ.ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

1. Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг

1.1.Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан **16 нийт арга хэмжээ** (энэхүү загварын 1.2-т дурдсан тусгай арга хэмжээ орохгүй)-г гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.

1.2.Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон **1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 2.1.1, 2.1.10, 2.1.12, (тусгай арга хэмжээ бүрийн дугаарыг заана) 9-н тусгай арга хэмжээг** гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.

1.3.Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны манлайллын зорилтын хүрээнд дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ: Хүснэгт 1

Манлайллын зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)
1	2	3
<p>1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар:</p> <p>Зорилт-1: Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах Зорилт-2: Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх Зорилт-3: Төрийн албыг чадварлаг хашиж, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй хүргэх</p>	<p>а) Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах б) Төрийн албан хаагчийн эрмэлзэх 9 зүйлийг мөрдлөг болгон ажиллах в) Иргэдэд эрх тэгш шударгаар үйлчлэх г) Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь тайлагнах д) Байгууллага хамт олноо мэргэжлийн удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд цаг тухайд нь шуурхай хүргэж, иргэдээс ирсэн өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж, шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлж ажиллах</p>	<p>Төрийн үйлчилгээ авлигаас ангид байж ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана.</p> <p>Жилдээ</p>

<p>2.Байгууллагын ил тод байдлыг хангах талаар:</p> <p>Зорилт-1: Төрийн байгууллагын үйлчилгээний чанарыг дээшлүүлж, хүнд суртлыг багасгах, байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах</p> <p>Зорилт-2:Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах</p>	<p>а) Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйл "Үйл ажиллагааны ил тод байдал", 8 дугаар зүйл "Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, үйл ажиллагааны талаархи мэдээ мэдээллийг вэб сайтад тогтмол оруулах</p> <p>б/Иргэдээс санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч түргэн шуурхай холбогдох дүрэм журмын дагуу шийдвэрлэх</p> <p>в) Байгууллагын үйл ажиллагаанд хувийн хэвшил холбоод, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог хангах</p> <p>г) Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт, үзэсгэлэнд тогтмол оролцож байгууллагын үйл ажиллагааг сурталчлах</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаа иргэдэд нээлттэй ил тод болно.</p> <p>Жилдээ</p>
<p>3.Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар:</p> <p>Зорилт-1: Төсвийн тухай хууль болон бусад холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийг хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх.</p> <p>Зорилт-2: Төсвийг хэмнэлттэй зарцуулж, төсвийн үргүй зардлыг бууруулах</p> <p>Зорилт-3:Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, хадгалалт, зарцуулалтын ил тод байдлыг хангах</p>	<p>а).Төсвийн төлөвлөгөө, гүйлгээ зарцуулалтыг шилэн дансанд байршуулах, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах</p> <p>б). Байгууллагын төсвийн орлого, зарлага болон тайлангийн бүх мэдээллийг олон нийтэд ил тод байхаар "Шилэн данс"-ны хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах</p> <p>в)Төсвийн сахилга батыг сайжруулах талаар гаргасан тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх</p> <p>г) Санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах</p>	<p>Дотоодын хяналт сайжирч, төсвийн сахилга дээшилнэ.</p> <p>Жилдээ</p>
<p>4.Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар:</p> <p>Зорилт-1: Байгууллагын үндсэн хөрөнгө болон хөтөлбөр, төслийн хүрээнд бэлтгэгдсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж хяналт тавих</p> <p>Зорилт-2:Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглаж, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх</p>	<p>а/Байгууллагын эд хөрөнгийн бүртгэл хяналтыг сайжруулж, эд хөрөнгийн тооллогыг 2 удаа явуулж, ашиглалтанд хяналт тавьж ажиллах</p> <p>б/Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг НББ-ийн хууль болон олон улсын стандартын дагуу хийх, системийн хэмжээнд мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэн ажиллах</p>	<p>Эд хөрөнгийн ашиглалт хамгаалалт сайжирна.</p> <p>Жилдээ</p>

<p>5.Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар: Зорилт-1: Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг сайжруулах</p> <p>Зорилт-2: Ажиллагсдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл баталгааг шат дараалалтай хангах</p>	<p>а) Мэргэжлийн болон мэргэшлийн дотоодын ба гадаадын сургалтанд албан хаагчдыг хамруулах</p> <ul style="list-style-type: none"> - Барилгын инженер С.Байгалмааг мэргэшсэн төсөвчний сургалтанд хамруулж мэргэшсэн төсөвчин болгох, - Парк ашиглалтын инженер Б.Батбилэгийг “ARCGIS”-газар зүйн мэдээллийн системийн программын сургалтанд хамруулах <p>б) Салбарын хэмжээнд шаардлагатай байгаа мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, бүрдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах</p> <ul style="list-style-type: none"> - Бичиг хэрэг, архив хариуцсан мэргэжилтэн Б.Норжмааг Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтанд хамруулах <p>в) Ажиллагсдыг сонгон шалгаруулж ажилд авах үйл ажиллагааг нээлттэй ил тод болгох зорилтын хүрээнд дараах ажлын байранд 2019-онд дараах ажлын байранд сонгон шалгаруулалт явуулна: Үүнд: - Цахилгааны инженер - Хүний нөөц хуульч</p> <p>г) Мэргэжилтэнүүдийг шаардлагатай техник хэрэгсэл эд материалаар хангах зорилтын хүрээнд дараах техник хэрэгсэлийг авч ажиллуулах боломжийг бүрдүүлнэ:</p> <ul style="list-style-type: none"> - GPS байршил тогтоох хэмжилт хийх багаж - Хэмжилт хийх теодилет, невелир багаж 	<p>Ажиллагсдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.</p> <p>Жилдээ</p>
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------

1.4. Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 2

Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт (шалгуур үзүүлэлт)	Зорилтыг хэрэгжүүлэх арга зам (өөрийгөө хөгжүүлэх чиглэл)	Хуанлийн хугацаа, хүн/өдөр
1	2	3
Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт-1: Удирдлага, Менежментийн талаархи мэдлэгээ дээшлүүлэх	а) Холбогдох хууль, тогтоол, шийдвэрийг уншиж судлах б) Дотоод болон гадаадад удирдлагын менежментийн сургалтанд хамрагдах в) Бие даан суралцана	10 хүн/өдөр Жилдээ
Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт -2: Паркийн болон Чөлөөт бүсийн туршлага судалсан байна.	а) Дотоодын паркттай танилцах б) Үйлдвэрлэл, технологийн паркттай холбоотой олон улсын туршлага судлах, танилцах в)Гадаадын аж үйлдвэрийн паркуудтай танилцах	5 хүн/өдөр Жилдээ

1.5. Үйл ажиллагаандаа Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон өөрийн эрхлэх асуудлын хүрээний холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.6. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан бодлогын баримт бичгийн уялдаа холбоог хангаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг байгууллагын жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хөтөлбөрийн биелэлтийг асуудал хариуцсан орлогчид сар бүр тайлагнаж, үр дүнг Засаг даргын өмнө хариуцна.

1.7. Улаанбаатар хотын “Хөгжлийн индекс”-ийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулан ажиллана.

1.8. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /KPI/-ээр үнэлүүлж, тусгай захиалгат бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт, дэвшилтэт өндөр технологи нэвтрүүлэх зорилтыг ханган ажиллана.

1.9. 2019 оныг “Иргэдийн оролцоотой – Хөгжлийн жил” болгон зарласантай холбогдуулан энэхүү ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулан байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулж Налайх дүүргийн иргэдийг ажлын байраар ханган ажиллана.

1.10. Байгууллагын хэмжээнд тулгамдаж буй шийдвэрлэх шаардлагатай асуудлаар 2-оос доошгүй ажлыг санаачилж хэрэгжүүлэн ажиллана.

1.11. 2018 оны байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгсөн ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжид тусгагдсан ажлуудыг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хагас бүтэн жилийн тайлангийн хамт үр дүнг үнэлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст ирүүлнэ.

1.12. Албан үүргээ гүйцэтгэхдээ нэгдмэл сонирхолтой болон хамаарал бүхий этгээдтэй холбоотойгоор олон нийтэд төрийн албан хаагч, төрийн албанд эргэлзээ төрүүлэх, итгэлийг алдах шинжтэй аливаа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байна.

1.13. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж ажиллана.

1.14. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлын хариуцан ажиллана.

1.15. Байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.

1.16. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дундын мэдээллийн сан www.erp.ulaanbaatar.mn, цахим хуудсыг ашиглана.

1.17. Эрхлэх асуудлын хүрээнд шүүхэд үүссэн маргаанд Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох бөгөөд үүсэх аливаа үр дагаварыг Засаг даргын өмнө бүрэн хариуцна.

1.18. Байгууллагын албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоол, төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 дугаар тогтоолыг тус тус баримтлан ажиллана.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг

2.1. Төсвийн шууд захирагчтай байгуулах гэрээнд тусгаж хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ (нийт болон тусгай арга хэмжээ)-нүүд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.2. Манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлно.

2.3. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллага хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай төсвийг эрх бүхий байгууллагаар батлуулна.

2.4. Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хугацаанд нь хийнэ.

2.5. Гэрээнд тусгагдсан хөтөлбөр, нийт болон тусгай арга хэмжээнүүд, манлайллын зорилтоо хэрэгжүүлэхэд нь төсвийн шууд захирагчид байнгын дэмжлэг туслалцаа үзүүлж, гэрээний биелэлтийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.6. Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу хагас, бүтэн жилээр үнэлж дүгнэнэ.

2.8. Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн оны гэрээний биелэлтийн тайлан болон дараа оны гэрээний төслөө хугацаандаа ирүүлээгүй төсвийн шууд захирагчид шаардлага тавьж, хэрэгжилтийг хангуулах эрхтэй.

ХОЁР.БУСАД ЗҮЙЛ

3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.1. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэж, албажуулан гэрээнд хавсаргана. Энэхүү гэрээний хугацаа сунгагдахгүй.

3.2. Байгууллагын үйл ажиллагааны гадаад, дотоод орчин өөрчлөгдсөний улмаас байгууллагын зорилт, чиг үүрэг, зохион байгуулалтын бүтэц, орон тоо өөрчлөгдсөн мөн нэмэлт хөтөлбөр, арга хэмжээг баталгаажуулах шаардлагатай гэж талууд үзсэн тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

4. Гэрээ байгуулах болон дүгнэх хугацаа

4.1. Гэрээг 2019 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусах хүртэл хугацаагаар байгуулав.

4.2. Төсвийн шууд захирагч гэрээний биелэлтийг 2020 оны 01 дүгээр сарын 05 -ны дотор багтаан тайлагнаж, төсвийн ерөнхийлөн захирагч 2020 оны 01 дүгээр сарын 15.-ны дотор багтаан түүний биелэлтийг дүгнэнэ.

5. Гэрээний урамшуулал ба хариуцлага

5.1. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 220 дугаар тогтоолоор баталсан “Нийслэл, дүүргийн

орон нутгийн төсвийн байгууллага, өмчит үйлдвэрийн газрын ажиллагсад үр дүнгийн урамшуулал олгох журам"-ын дагуу болон холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, журамд заасан урамшуулал олгож болно.

5.2. Төсвийн шууд захирагч гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6. Гэрээ байгуулсан:

Төсвийн ерөнхийлөн захирагч:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч

(албан тушаал)



Тэмдэг

2019.04.23

(огноо)

Төсвийн шууд захирагч

“Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл,
Технологийн Парк” Орон Нутгийн Өмчит

Төсөвт Үйлдвэрийн Газрын Дарга

/Сосорын Батжаргал/

(албан тушаал)

(гарын үсэг)

Тэмдэг



(огноо)

**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
(2019 он)**

НЭГ.НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<p><i>Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i></p>	<p><i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i></p>	<p><i>Тухайн нийт арга хэмжээний төсвийн захирагчийн өгсөн үнэлгээ (Нийт арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i></p>
1	2	3
<p>2.1. "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх</p> <p>Арга хэмжээ – 2.1.2: Паркийн өргөтгөл 130 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх.</p> <p>Арга хэмжээ – 2.1.3: Паркт байрших үйлдвэрүүдийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>Арга хэмжээ – 2.1.4: Паркт байрших үйлдвэрүүдийн усан</p>	<p>- 130 га газарт ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгавар боловсруулан баталж өгөхийг Нийслэлийн хот байгуулалт Хөгжлийн газраас 2019.06.06 өдрийн 112 дугаар албан тоотой хүссэн. Хот байгуулалт, Хөгжлийн газраас төсөл бэлдэж ирүүлэхийг хүссэн тул төслийг 2019 оны 06 сарын 13 өдөр бэлтгэн хүргүүлсэн. Мөн шаардлагатай хөрөнгө оруулалт болох 254 сая төгрөгийн төсвийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн засаг даргад албан хүсэлтээр хүргүүлсэн.</p> <p>- Бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулан паркийн 630 кВ-ын цахилгааны дэд өртөөнөөс эх үүсвэрийг татан ажиллаж байна. Мөн Эрчим хүчний яамны 2019.10.25-ны өдрийн 65с/2019/87 дугаар техникийн нөхцөлийг сунгуулсан.</p>	

<p>хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>Арга хэмжээ – 2.1.5: Паркт байрших үйлдвэрүүдийн хог хаягдлыг ангилах, зөөж тээвэрлэх асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>Арга хэмжээ – 2.1.6: Паркийн цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах.</p> <p>Арга хэмжээ – 2.1.7: Паркийн усан хангамжийн ажлын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.</p>	<ul style="list-style-type: none"> - Паркийн хэрэгцээг бүрэн хангах 8,96 л/сек хүчин чадал бүхий гүний худаг хэвийн үйл ажиллагаатай байгаа бөгөөд бүтээн байгуулалтаа хийж буй аж ахуйн нэгжүүдтэй зөөврийн усны гэрээ байгуулан ажиллаж байна. - Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний хэлтэс, үйлдвэрлэл технологийн парк, аж ахуйн нэгжүүдтэй хог хаягдал ачиж тээвэрлэх гурвалсан гэрээ байгуулан Налайх дүүргийн төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг тээвэрлэж байна. - Хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ажлын зураг, төсөвт өртгийн мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг 2020-оны Улсын төсөв болон Концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар БХБЯам, Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх 6-р сарын 8,9 ны өдрүүдэд Налайх дүүрэг болон Үйлдвэр технологийн Паркт ажиллах үед паркийн нэн шаардлагатай байгаа дэд бүтцүүдийн талаарх мэдээлэл өгч Монгол Улсын Засгийн Газрын хуралдаанаар паркийн Цэвэрлэх байгууламж, Цахилгаан хангамжийн төсөвт өртгийг 2020 оны төсөвт суулгуулах талаар Засгийн Газрын тэмдэглэл гарсан болно. - Паркийн нийт усны хэрэгцээг хангах 8,96 л/сек хүчин чадал бүхий 2 гүний худаг бэлэн болсон ба эхний ээлжийн үйлдвэрүүд болон авто зам, үерийн барилга байгууламжийг зөөврөөр ундны, хэрэглээний усаар ханган ажиллаж байна. - Хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ажлын зураг, төсөвт өртгийн мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг 2020-оны Улсын төсөв болон Концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар барилга хот байгуулалтын яам, Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хүргүүлсэн. 	
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

<p>Арга хэмжээ – 2.1.8: Паркийн салбар төмөр замын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.</p> <p>Арга хэмжээ – 2.1.9: Паркийн дулааны станцын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.</p> <p>Арга хэмжээ – 2.1.11: Паркт ажиллах үйлдвэрүүдэд хүний нөөцийг бэлтгэх.</p> <p>Арга хэмжээ – 2.1.13: Авилгын эсрэг, авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах.</p>	<ul style="list-style-type: none"> - Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 10 өдрийн А/171 дугаар захирамжаар төмөр замын трасс дагуух 15 км /11,4 га/ газрын зөвшөөрлийг олгосон. Мөн 2018 оны 10 дугаар сарын 11 өдрийн А/962 дугаар нийслэлийн засаг даргын захирамжаар 15 га газар олгогдсоноор нийт төмөр замын трасст орсон 26.4 га газрын зөвшөөрөл бүрэн гарсан. Хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ажлын зураг, төсөвт өртгийн мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг 2020-оны Улсын төсөв болон Концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар Зам Тээвэр Хөгжлийн Яам, Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хүргүүлсэн. - Хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ажлын зураг, төсөвт өртгийн мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг 2020 оны Улсын төсөв болон Концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар Эрчим Хүчний яам, барилга хот байгуулалтын яам, Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад албан бичгээр хүсэлт гаргасан. - Паркт байгуулагдаж буй 2 барилгын материалын үйлдвэрт Налайх дүүргийн 50 иргэнийг байнгын ажлын байраар хангахад зуучлан, мөн бүтээн байгуулалтын хүрээнд авто зам, үерийн байгууламжийн түр ажлын байранд 100 орчим дүүргийн иргэнийг ажлын байраар ханган ажилласан байна. - Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн хүрээнд хариуцлага тооцуулах албан бичиг ирээгүй бөгөөд дээрх хугацаанд илэрсэн зөрчил байхгүй болно. 	
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

<p>Арга хэмжээ – 2.1.14: Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014.05.05-ны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах" журмын дагуу хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг шийдвэрлүүлэн өмчийн нэгдсэн бүртгэлийн санд хөрөнгийн өөрчлөлтийг хийж дахин үнэлгээний тооллогын дүнг баталгаажуулж нэгтгүүлэх.</p> <p>Арга хэмжээ – 2.1.15: Өмч эзэмшлийн гэрээ хийж хэрэгжилтийг хангаж ажиллах.</p>	<p>- Газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн А/21 тоот тушаалаар байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг байгуулж төлөвлөгөө боловсруулан байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилийн тооллогыг зохион байгуулан баталгаажуулан ажилласан.</p> <p>- 2019 онд өмч эзэмшлийн гэрээ байгуулаагүй болно.</p>	
<p>2.2. Паркийг олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор үйлдвэрүүд болон иргэд олон нийттэй уулзалт өдөрлөг зохион байгуулах</p> <p>Арга хэмжээ -2.2.1: Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад, иргэд, аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, Паркийн танилцуулга материал, товхимлуудыг түгээж зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд оролцоно.</p> <p>Арга хэмжээ -2.2.2: Мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллагууд, үйлдвэрүүдтэй хамтран хурал, зөвлөгөөн зохион байгуулж, судалгаа, шинжилгээ хийнэ.</p>	<p>- 2019 онд паркийн оффисын байранд нийтдээ 26 удаагийн уулзалт зохион байгуулсан ба харъяа дээд газруудаас зохион байгуулсан бизнес уулзалт, хөрөнгө оруулалтын үзэсгэдэн яармаг болон нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд оролцон паркийн мэдээллийг олон нийт, аж ахуйн нэгжүүдэд танилцуулсан бөгөөд тухай бүрт паркийн албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэж 5 удаагийн телевизийн ярилцлага, 2 удаа сонинд ярилцлага өгсөн.</p> <p>- Барилгын салбарын үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагч нарыг хамруулсан өдөрлөг, уулзалтуудад тухай бүр оролцон паркийн үйл ажиллагааг идэвхитэй сурталчилж холбогдох дээд албан байгууллагуудад паркийн хөрөнгө оруулалтыг дэмжих талаарх хүсэлтүүдийг удаа дараа хүргүүлсэн.</p>	

<p>Арга хэмжээ -2.2.3: Барилгын материалын салбарынханд чиглэсэн уулзалт, хурал, зөвлөгөөн гэх мэт тодорхой арга хэмжээнүүдийг зохион байгуулж, арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцоно.</p> <p>Арга хэмжээ -2.2.4: Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, түншийн харилцааг бий болгоно.ҮТП-н талаар ярилцлага хүргэнэ</p>	<ul style="list-style-type: none"> - Барилгын материалын салбарынхан, олон нийтийг хамруулсан 5 өдөрлөг, уулзалт, хурал зөвлөгөөнд оролцон 1 зөвлөгөөн зохион байгуулсан. - Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, түншийн харилцааг бий болгох талаар Монгол HD, NTV, Star TV, TV5, MN25, Эх орон тв, Сүлд тв, VTV, Eagle tv, ЕКО tv зэрэг сувгуудын нэвтрүүлгийн судалгаа хийсэн. - Мөн байгууллагын үйл ажиллагааны талаар Ikon news мэдээллийн сайтад “Зуун айлын үйлдвэрүүдийг хотоос 35км-т нүүлгэнэ” сэдэвт мэдээ, мөн Зууны мэдээ сонинд “Хонгилын үзүүрт гэрэлтэх үйлдвэрлэл, технологийн парк” сэдэвт мэдээ тус тус нийтлэгдсэн байна. - Паркийн талаарх мэдээ мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулж иргэд олон нийт, хөрөнгө оруулагч үйлдвэрлэгч нарт мэдээллэж байна. - Сар бүр шилэн дансанд мэдээлэл оруулан захирамжлалын бичиг баримтыг цаг тухай бүрт цахимжуулан ажиллаж байна. - Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлыг Нийслэлийн Засаг даргын 2013 оны 12 сарын 10-ны А/1086 дугаар захирамжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Тус газарт НҮНТ-өөр дамжуулан аж ахуйн нэгж, иргэнээс өргөдөл гомдол ирээгүй болно. Байгууллагын хэмжээнд албан хаагчидтай холбоотой нийт 12 өргөдөл ирсэнээс www.smartcity.mn цахим программд бүртгэн тухай бүрт нь шийдвэрлэсэн болно. 	
Нийт арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО		30

ХОЁР.ТУСГАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:

<p><i>Гэрээнд тусгагдсан тусгай арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин</i></p>	<p><i>Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)</i></p>	<p><i>Тухайн тусгай арга хэмжээний биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Тусгай арга хэмжээ бүрийн биелэлтэд 0-40 оноо)</i></p>
1	2	3
<p>1. "Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн Үйл ажиллагааны хэрэгжилт 30 хувь, Үерийн барилга байгууламж барих ажлын гүйцэтгэл 100 хувь, Налайх-Чойрын чиглэлийн төв замд холбосон авто замын урт 4.64 км</p> <p>Арга хэмжээ -1.1: Үерийн барилга байгууламжийг байгуулах ажлыг барьж байгуулах.</p> <p>Арга хэмжээ -1.2: Паркийн авто замын ажлыг барьж байгуулах.</p>	<p>- 1635 метр үерийн барилга байгууламжийн өндөржилтийн зөрүү гарсан ажлын зураг төсөлд өөрчлөлт оруулан трасс дагуух газрын бэлтгэл ажлыг ханган 2019 оны 5-р сарын 15-наас 2-р ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн ба ажлын явц 80 орчим хувийн гүйцэтгэлтэй байна. Санхүүжилт 30 орчим хувь хийгдсэн ба ирэх 2020 онд бүрэн дуусгахаар болсон.</p> <p>- Нийслэлийн засаг даргын 2018.09.26-ны өдрийн А/888 тоот захирамжаар паркийн гадна авто зам буюу “Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн авто замаас паркийн зүүн хойд цэг хүртэлх 4,64 км авто замын байгууламжийн ажлыг гүйцэтгэхийг “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг НАЗХГазарт үүрэг болгосон. Авто замын барилга угсралтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй ба 2020 онд явган зам, ногоон байгууламж, тэмдэг тэмдэглэгээг гүйцээх юм. Зорчих хэсгийн үндсэн зурвасын ажил бүрэн дууссан.</p>	

<p>Арга хэмжээ -1.3: 110/10кВ-ын дэд өртөөний барилга угсралтын ажлыг эхлүүлэх.</p>	<p>- 110/10 кВ-ын шугам, дэд станцыг байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн төсвөөс 1 тэрбум төгрөг тусгагдсан ба 2019 оны 05-р сарын 14-ний өдөр Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас “НБМҮТП” ОНӨТҮГ-ын Үндсэн цахилгаан хангамжийн эхний ээлжийн 110 кВ-ын дэд станц, удирдлагын байрыг барьж байгуулах сонгон шалгаруулалт зарласан ба 2019.11.25-ны өдөр НЗДТГ, НХОГ гүйцэтгэгч байгууллагаар шалгарсан “Хасу-Эрчим” ХХК-тай гурвалсан гэрээ байгуулсан. 2020 оноос бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр бэлтгэл ажлууд хийгдэж байна.</p>	
<p>Арга хэмжээ -1.4: 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлын зураг төсөл.</p>	<p>- Нийслэлийн Засаг даргын 2019.06.21-ний өдрийн А/617 тоот эрх шилжүүлэх захирамжийн дагуу газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/32 тоот тушаалаар Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөл өөрчлөгдсөнтэй холбогдон ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр зарлан гүйцэтгэгч байгууллагаар “Дархан сүлжээ” ХХК шалгаран өөрчлөлтийн зураг төслийг гүйцэтгэж байна.</p>	
<p>Арга хэмжээ -1.5: Шинээр үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах.</p>	<p>- 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 30 аж ахуйн нэгж, 3 иргэн парк байрших хүсэлт ирүүлсэн ба тэдгээрийн төсөл, шинэ технологийн талаарх мэдээллийг судалж дүгнэлтийг гарган холбогдох дээд газруудад тайлагнан ажилласан.</p>	
<p>Арга хэмжээ -1.6: Гэрээний дагуу үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.</p>	<p>- Нийт 27 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулснаас 2019 онд 9 аж ахуйн нэгж, 3 иргэнтэй гэрээ байгуулсан бөгөөд 2 аж ахуйн нэгж үйлдвэрийн барилга байгууламжаа барин эхний бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж эхлээд байна. - 4 үйлдвэрийн архитектур төлөвлөлтийн даалгаврыг гаргуулсан.</p>	

<p>Арга хэмжээ - 2.1.1: Паркийн өргөтгөлийн 130 га газрын зөвшөөрөл шийдвэрлүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол улсын засгийн газрын 2011 оны 104-р тогтоолын 1-р хавсралт “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан өндөр технологи нэвтрүүлсэн, байгаль орчинд халгүй 27 аж ахуйн нэгжтэй үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулснаас 6 үйлдвэр бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлэн ажиллаж байна. - 2019 оны байдлаар “Бэст трейд лайн” ХХК сандвич хавтангийн үйлдвэр, “Эс Жи Ди Эм” ХХК нарны панелийн үйлдвэр, “Эко минерал” ХХК зэс утас, гуулин трубаны үйлдвэр, “Цогт цэций хайрхан” ХХК электролын үйлдвэрүүд бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлэн төлөвлөгдсөн талбайгаа хашаажуулан агуулахаа байрлуулсан. - “Хажерын гол” ХХК нь хуурай хольцын үйлдвэр бөгөөд 2019 оны 9 дүгээр сараас дээж бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн сорилын шинжилгээнд хүргүүлсэн ба одоогоор 4 ажилчинтай дотооддоо борлуулалт хийж байна. - Бүгд найрамдах Хятад ард улсын хөрөнгө оруулалттай ширэм болон ган цутгамал бүтээгдэхүүний үйлдвэр “Пийс стийл групп” ХХК нь НБМҮТ Паркийн анхны үйлдвэр болон ашиглалтад орж эхний ээлжинд Налайх дүүргийн 50 иргэнийг ажлын байраар хангаад байна. Налайх дүүргийн иргэд илүү аюулгүй орчинд тогтмол цалинтай ажиллаж амьдрах бүрэн боломж үүсэж байна. 100% экспортын бүтээгдэхүүн. - Паркийн өргөтгөлийн 130 га газрын зөвшөөрөл шийдвэрлүүлэх: 2019.03.01 өдрийн 30 дугаар албан тоотой Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 2019.05.21 93 Налайх дүүргийн Газрын албанд хүсэлт гаргаж давхцал үүссэн эсэх талаар тодорхойлолт авч ажилласан. Паркийн бүсийн 2 дугаар ээлж болох 130 га газрын захирамж гаргуулах захирамжийн төсөл болон холбогдох материалын бүрдлийг хангаж өгснөөр Нийслэлийн засаг даргын 2019 оны 05 сарын 30-ны өдрийн А/526 захирамжаар Газар эзэмших 	
---------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

<p>Арга хэмжээ - 2.1.10: 100 айл орчмын барилгын материалын үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллах.</p> <p>Арга хэмжээ - 2.1.12: "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил"-ийн ажлын хүрээнд шинээр ажлын байр бий болгох.</p>	<p>эрх олгосон. Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт шинээр 130 га газрыг үйлдвэрлэл технологийн паркийн үйлдвэрлэлийн зориулалтаар, 4.7 га газрыг шилэн кабелийн зориулалтаар тус тус “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ-т 15 жилийн хугацаатай эзэмших эрх олгосон.</p> <p>- Паркийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ханын материалын үйлдвэрлэлийн бүс болон жижиг дунд үйлдвэрлэлийн бүсийг хамруулан 13 га газарт дэд бүтцийн шугам сүлжээ, зам талбайд тохируулан 0,05га /500м2/ эдэлбэр газар бүхий 126 аж ахуйн нэгжийн төлөвлөгөө боловсруулсан ба 2019 оны жилийн эцсийн байдлаар байдлаар 3 аж ахуйн нэгж 3 иргэнтэй үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулаад байна.</p> <p>- 100 айлын барилгын материалын үйлдвэрлэл эрхлэгчдийн судалгаа хийгдсэн ба эхний ээлжийн 26 аж ахуйн нэгж болох мод, чулуу, дээврийн төмөр, вакум цонхны үйлдвэрлэл эрхлэгчдийн нэрсийг гарган бэлэн болсон.</p> <p>- 2019 оны 2 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн иргэний танхимд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас гарсан ажлын хэсгийн илтгэл, хэлэлцүүлэг хийгдсэн ба нийт 400 гаруй хүн цугларсан.</p> <p>- Паркт үйл ажиллагаа эрхэлж буй үйлдвэрүүдэд ажиллах хүний нөөцийг Налайх дүүргийн иргэдээс төвлөрүүлж байгаа бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 365 иргэний ажилд орох хүсэлтийг бүртгэн 150 иргэнийг ажлын байраар хангаад байна. Мөн Налайх дүүргийн хөдөлмөрийн үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллаж байна.</p>	
<p align="center">Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО</p>		<p align="center">40</p>

ГУРАВ. МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ:

<p><i>Гэрээнд тусгагдсан манлайллын зорилт (орц), түүний шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшин</i></p>	<p><i>Жинхэнэ гүйцэтгэл (шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшин)</i></p>	<p><i>Тухайн манлайллын зорилтын биелэлтэд төсвийн ерөнхийлөн захирагчийн өгсөн үнэлгээ (Манлайллын зорилт бүрийн биелэлтэд 0-30 оноо)</i></p>
1	2	3
<p>1. Зорилт 1: Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх</p> <p>1.1. Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажиллах</p> <p>1.2. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх</p> <p>1.3. Төрийн албыг чадварлаг хашиж, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй хүргэх</p>	<p>- Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйлийг мөрдлөг болгон холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллаж байна. Ажилтануудтай хөдөлмөрийн гэрээ байгуулан захирамжлалын баримт бичгүүдийг боловсронгуй болгон ажиллаж байна.</p> <p>- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилж, байгууллагын хэмжээнд ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>- Нутгийн захиргааны байгууллагууд erp.ulaanbaatar.mn нэгдсэн системд холбогдон бүх шатны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан иргэдэд үзүүлэх үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, чирэгдэлгүй үзүүлж байна.</p>	
<p>2. Зорилт 2: Байгууллагын ил тод байдлыг хангах</p> <p>2.1. Төрийн байгууллагын үйлчилгээний чанарыг дээшлүүлж, хүнд суртлыг багасгах, байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах</p>	<p>- Нийслэлийн засаг даргын 2018.05.24-ний өдрийн А/335 дугаар захирамжын дагуу Байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор цахим хуудасны мэдээллийг тогтмол</p>	

<p>2.2. Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах</p>	<p>шинэчлэн байршуулж байгаа бөгөөд хандалтыг нэмэгдүүлэх зорилгоор facebook хуудсанд холбосон. Одоогоор энэ хуудас нь 2500 гишүүнтэй болоод байна.</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн байгууллагын ил тод, нээлттэй, байдлыг ханган төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй ажиллаж байгаа бөгөөд 2019 оны байдлаар аж ахуйн нэгж, иргэдээс өргөдөл гомдол ирээгүй болно. - Smartcity программд холбогдсон бөгөөд одоогийн байдлаар энэ програмаар иргэдээс өргөдөл, гомдол, санал ирээгүй. - Тус газар нь хүний нөөцийн хувьд батлагдсан тоондоо буюу нийт 14 ажилтан ажиллаж байна. Ажилтнуудын ажил, үүргийн хуваарь болон бусад шаардлагатай мэдээллүүдийг байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд байгуулсан. 	
<p>3. Зорилт 3: Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах</p> <p>3.1. Төсвийн тухай хууль болон бусад холбогдох эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийг хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх.</p> <p>3.2. Төсвийг хэмнэлттэй зарцуулж, төсвийн үргүй зардлыг бууруулах.</p> <p>3.3. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, хадгалалт, зарцуулалтын ил тод байдлыг хангах.</p>	<ul style="list-style-type: none"> - Төсвийн хөрөнгийг ямар нэгэн байдлаар зориулалтын бус зүйлд зарцуулаагүй болно. - Байгууллагын санхүүгийн тайлан, балансийг нийслэлийн Аудитын газраар баталгаажуулсан. Аудитын дүгнэлтийг www.nalaikhpark.mn цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан. - Хуульд заасан шаардлагын дагуу холбогдох тайлан, мэдээг гаргаж, байгууллагын цахим хуудсыг www.shilendans.gov.mn цахим хуудаст холбон хугацаанд нь тухай бүр байрлуулж байна. 	
<p>4. Зорилт 4: Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах</p>		


<p>4.1. Байгууллагын үндсэн хөрөнгө болон хөтөлбөр, төслийн хүрээнд бэлтгэгдсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж хяналт тавих.</p> <p>4.2. Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглаж, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх</p>	<p>- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 13-ны А/35 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу байгууллагын 2019 оны хагас болон жилийн эцсийн тооллогын комисс томилж байгууллагын үндсэн эд хөрөнгө, хангамжийн материалын тооллого хийн тайлан боловсруулсан. Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавин анхан шатны болон бусад баримтуудыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, холбогдох тайланг цаг тухай бүрт бэлтгэн ажиллаж байна.</p> <p>- Байгууллагын биет хөрөнгийн нөөцийг зориулалтын дагуу ашиглаж өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавин анхан шатны болон бусад баримтуудыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, холбогдох тайланг цаг тухай бүрт бэлтгэн ажиллаж байна.</p>	
<p>5. Зорилт 5: Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх</p> <p>5.1. Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг сайжруулах.</p>	<p>- Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хүрээнд ажилтан бүрээр ур чадварын үнэлгээг хийж байгууллагын хэмжээнд 81,8 хувьтай үнэлсэн. Мөн хамт олны дунд эерэг хандлагыг түгээх, ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор “Эерэг байцгаая” сарын аяныг зохион байгуулж ажилласан.</p> <p>- Байгууллагын 2019 оны Сургалт хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу нийт 11 төрлийн сургалтад ажилтнуудыг хамруулахаар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар хуваарийн дагуу 8 сургалтыг дотооддоо ажилчид зохион байгуулж, сургалтын байгууллагаас захиалгат 1 сургалт авсан байна. Давхардсан тоогоор нийт 67 ажилтан хамрагдсан.</p> <p>Хүний нөөцийн 2019 оны төлөвлөгөөнд Ажилтнуудын эрүүл мэнд, чийрэгжүүлэлт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх</p>	

<p>5.2. Ажиллагсдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл баталгааг шат дараалалтай хангах.</p>	<p>чиглэлээр 9 арга хэмжээ төлөвлөн ажилласан. Төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Уул уурхайн аврах ангитай гэрээ байгуулан 7 хоногт 1 удаа спортоор хичээллэн өнгөрүүлж байна. - Суудлын өвчин, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж нийт ажилчид ширээний теннис болон, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшсэн. - Байгууллагын ажилчид сард 1 удаа Богд уулын Цэцээ гүн оргил, Майхан уул руу явган алхалт хийж байна. - Ажилчдын чөлөөт цаг болон мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх үүднээс “Кофетой өглөө” чөлөөт, сэдэвчилсэн хэлэлцүүлгийг 10 удаа зохион байгуулсан. - Байгууллагын ажилчдыг идэвхижүүлэх, дэмжих, олон нийтийн оролцоог сайжруулах зорилгоор баяр ёслол болон бусад зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. 	
Манлайллын зорилтын биелэлтийн ДУНДАЖ ОНОО		<u>30</u>

Тайлан гаргасан:

.....

Төсвийн шууд захирагч:



..... /...С.Батжаргал...../

Үнэлгээ өгсөн:

.....

(албан тушаал)

Төсвийн ерөнхийлөн захирагч:

..... /...../

(гарын үсэг)